

- хар тамхи, мансууруулах буюу хордуулах бодис,
- хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын болон гадаад улсын мөнгөн тэмдэгт,
- түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн,
- садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад материал,
- хууль тогтоомжоор хориглосон бусад зүйл.

### 5. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөгдөх илгээмж:

-Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.15 дахь заалтад заасны дагуу хувь хүний нэр дээр ирсэн дараах илгээмжийг **гаалийн татвараас** чөлөөлнө.

-Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий, хувь хүний нэр дээр илгээсэн илгээмж.

-Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.24 дахь заалтад заасны дагуу хувь хүний нэр дээр ирсэн дараах илгээмжийг **нэмэгдсэн өртгийн албан татвараас** чөлөөлнө.

-Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин, зөврийн компьютерийн хувьд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гуч дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий, хувь хүний нэр дээр илгээсэн илгээмж.

Танд лавлах зүйл байна уу!



**1800-1281**

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулг



Санал

### ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “**Гаалийн лавлах-1281**” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



**Хаяг:**  
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",  
Улаанбаатар-14193, Монгол Улс  
**Утас:** (976-11) - 350049  
**Факс:** (976-11) - 350048  
**E-mail:** info@customs.mn  
**Интернет:** http://www.customs.gov.mn



МОНГОЛ УЛСЫН  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ШУУДАН ИЛГЭЭМЖИЙГ  
ГААЛИЙН ХИЛЭЭР  
НЭВТРҮҮЛЭХ ТУХАЙ



## 1. Эрх зүйн хэм хэмжээний акт

- Дэлхийн Шуудан Холбооны конвенц;
- Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц;
- Шуудангийн тухай хууль;
- Гаалийн тухай хууль;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;

- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2014 оны 269/264 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Улс хоорондын шуудан илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”;

- ГТЕГ-ын даргын 2016 оны А/236 дугаар тушаалын хавсралтаар батласан “Гаалийн хяналтын нийтлэг журам”;

- Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2008 оны 30 дугаар тушаалаар батлагдсан “Шуудангийн үйлчилгээ үзүүлэх дүрэм”.

## 2. Шуудангийн тухай хуулийн нэр томъёо:

1. “**шуудан**” гэж шуудангийн илгээмжийг хаягласан эзэнд нь хүргэх үйлдвэрлэл-технологийн иж бүрэн үйл ажиллагаа бүхий харилцаа холбооны төрлийг;



2. “**шуудангийн илгээмж**” гэж үйлчлүүлэгчээс шуудангийн сүлжээ ашиглан, хаягласан эзэнд нь хүргүүлэхээр захидал, боодол, илгээлтийн хэлбэрээр хүлээлгэн өгсөн биет зүйлийг;



3. “**захидал**” гэж тодорхой этгээдэд хаягласан 500 граммаас илүүгүй жинтэй, дугтуйлсан болон дугтуйлаагүй шуудангийн илгээмжийг;



4. “**боодол**” гэж 1000 граммаас илүүгүй жинтэй, урт нь 245 мм, өндөр нь 35 мм, өргөн нь 150 мм-ээс илүүгүй хэмжээтэй савласан, захидлаас бусад шуудангийн илгээмжийг;

5. “**илгээлт**” гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмжийг.

## 3. Илгээмжид гаалийн бүрдүүлэлт хийх:

- “Эдийн тодорхойлолтын маягт” (CN22, CN23, CP72 г.м.)-аар гаалийн бүрдүүлэлт хийх бараа:

- “Эдийн тодорхойлолтын маягт болон дагалдах бусад бичиг баримтад тухайн илгээмжтэй холбоотой, гаалийн байгууллагад шаардлагатай мэдээлэл бүрэн багтсан

бол уг маягтыг дор дурдсанаас бусад бараанд гаалийн мэдүүлэг гэж үзнэ:

## -Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлт хийх бараа:

-аж ахуйн нэгж, байгууллагад хилийн чанадаас илгээсэн 100.0 мянган төгрөгөөс илүү үнэ бүхий бараа,

-шинжлэх ухаан, техникийн ололт, газар нутгийн загвар дүрс, зураг зүйн болон бусад материал, судалгаа, шинжилгээ, геологи, байгаль, амьтан судлал, палентологийн олдворын болон бусад бүх төрлийн дээж, сорьц зэрэг онцлог бараа,

-Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх бараа,

-экспортын татвартай бараа,

-барааг дотоодын хэрэглэнд зориулан оруулах, хилийн чанадад бүрмөсөн гаргахаас бусад горимоор гаалийн хилээр нэвтрүүлэх бараа.

## “Гаалийн бүрдүүлэлтийн хуудас” (Маягт 2)-аар гаалийн бүрдүүлэлт хийх бараа:

-аж ахуйн нэгж, байгууллагад хилийн чанадаас илгээсэн 100.0 мянган төгрөгөөс илүүгүй үнэ бүхий загварын бараа, танилцуулга, сурталчилгааны зориулалттай буюу мэдээллийн шинж чанартай ном, сэтгүүл, хуурцаг, бусад зүйлс,

-хувь хүний нэр дээр хилийн чанадаас илгээсэн нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнээс илүүгүй ижил төрлийн хоёроос илүү үнэ бүхий бараа.

## 4. Шуудангаар илгээхийг хориглох бараа:

-галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодис, түргэн шатамхай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл,

-хортон ургамал, амьтан,